



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 29 өдөр

Дугаар 4/238

Арвайхээр

Журам батлах тухай

Соёлын тухайн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.“Түүх соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах журам”-ын хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын Газрын Нийгмийн Бодлогын хэлтэс (Б.Сайнжаргал), аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газар (Ж.Пүрэвсүрэн), сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай

ЗАСАГ ДАРГА

Г.ГАНБОЛД

011100485

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2020 оны
дугаар сарын 05 ёдрийн 05 дугаар
захирамжийн хавсралт

ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛЫГ **ХАМГААЛАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Өвөрхангай аймгийн нутаг дэвсгэрт орших түүх соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалахтай холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.

Хоёр. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг иргэдэд гэрээгээр хамгаалуулахад төрийн байгууллагуудын оролцоо

2.1.Сумын Засаг дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

2.1.1. Тухайн хамгаалагч Түүх, соёлын үл хөдлөх дурсгал, гэрээт хамгаалагчийн тоо, соёлын өвийг хамгаалах зардлыг аймгийн Засаг даргад уламжилна.

2.1.2.Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг иргэдийн оролцоотой хамгаалж буй ажлын тайлан, үр дүнг аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газарт жил бүр танилцуулна.

2.1.3. Хамгаалалтын бүсэд орших түүх, соёлын үл хөдлөх дурсгал, дурсгалт газрын хамгаалалтад хяналт тавьж, устах, эвдрэх, гэмтэх аюул учирч байгаа соёлын өвийг авран хамгаалах, сэргээн засварлах, хайсжуулж хашлагажуулах, уламжлуулах арга хэмжээг үе шаттай зохион байгуулна.

2.1.4.Гэрээт хамгаалагчийн тухайн жилийн үүрэг хариуцлага, ажлыг дүгнэж, гэрээг сунгах эсэхийг тогтоох эрх бүхий “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах зөвлөл”-ийг /цаашид зөвлөл гэх/ байгуулна. Зөвлөлийн бүрэлдэхүүнд соёлын ажилтан, байгаль орчны улсын байцаагч, бусад төрийн албан хаагч, иргэдийн төлөөлөл орох бөгөөд тухайн сумын Засаг даргын захирамжаар томилно.

2.1.5.Холбогдох газруудтай хамтран түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг газрын кадастрын улсын бүртгэлд бүртгүүлнэ.

2.1.6.Гэрээт хамгаалагчийн үүрэг оролцоонд хяналт тавина.

2.2. Багийн Засаг дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

2.2.1.Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалахдаа (Багийн Засаг дарга, Соёлын төвийн эрхлэгч, иргэн) “гурвалсан гэрээ” байгуулна.

2.2.2.Соёлын төвтэй хамтран багийн нутаг дэвсгэрт орших түүх, соёлын үл хөдлөх дурсгалын байршлын зураглал гаргаж, тухайн иргэнд нэг болон түүнээс дээш дурсгалыг хамгаалуулах төлөвлөлтийг хийж, гэрээнд тусгана.

2.2.3.Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах үйл ажиллагаанд олон нийтийг татан оролцуулна.

2.2.4. Соёлын өвийн боловсролыг дээшлүүлэх ажлыг гэрээт хамгаалагчтай хамтран тухайн газар нутгийн ойролцоо айл өрхүүдэд зохион байгуулж, тайланг Соёлын төвд хагас, бүтэн жилээр ирүүлнэ.

2.2.5. Багийн Засаг дарга гэрээт хамгаалагчид үүрэг чиглэлийн дагуу шаардлага тавина.

2.4. Сумын Соёлын төв дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

2.4.1. Соёлын төвөөс гэрээт хамгаалагчид үнэмлэх олгоно.

2.4.2. Багийн Засаг даргатай хамтран тухайн багийн нутаг дэвсгэрт орших түүх, соёлын үл хөдлөх дурсгалын байршлын зураглал гаргаж, тухайн гэрээт хамгаалагчид нэг болон түүнээс дээш дурсгалыг хамгаалах төлөвлөлтийг хийнэ.

2.4.3. Соёлын өвийн боловсролыг дээшлүүлэх соёл, танин мэдэхүйн ажил, гэрээт хамгаалагчийн тайланг аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар, аймгийн Музейд жил бүрийн 12 дугаар сарын 15-ны дотор ирүүлнэ.

2.5. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг гэрээт хамгаалагч нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

2.5.1. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг гэрээт хамгаалагч иргэн нь тухайн дурсгалаас 25 км-ээс холгүй амьдардаг сумын харьят иргэн байна.

2.5.2. Түүх, соёлын дурсгалт газрын хамгаалалтын дэглэмийг сахиулна. Дэглэм сахиулахтай холбоотой зөрчлүүдийг Соёлын төвийн эрхлэгч, багийн Засаг дарга, байгаль орчны улсын байцаагч, Цагдаагийн байгууллагад болон холбогдох эрх бүхий албан тушаалтанд нэн даруй мэдэгдэнэ.

2.5.3. Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн хүрээнд хайгуул малтлага хийж байгаа этгээдийн зөвшөөрлийг шалгана.

2.5.4. Сард 1-ээс доошгүй удаа Соёлын төвийн эрхлэгчид түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хэрхэн хамгаалж буй, хадгалалт хамгаалалтын талаарх мэдээллийг /утсаар, бичгээр/ өгнө.

2.5.5. Өөр нутаг оронд шилжих, нүүдэл хийхээр болсон тохиолдолд холбогдох ажилтанд нэн даруй мэдэгдэнэ.

2.5.6. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалд байгалийн болон хүний оролцоотой аюул учрах үзэгдэл, үйл ажиллагаа болсон тохиолдолд нэн даруй соёлын төвийн эрхлэгч, багийн Засаг дарга, байгаль орчны улсын байцаагч болон холбогдох эрх бүхий албан тушаалтанд мэдээлнэ.

2.5.7. Багийн Засаг дарга, соёлын төвийн эрхлэгчтэй хамтран айл саахалт, нутгийн иргэд, хүүхэд залуучуудад соёлын өвийг хайллан хамгаалах талаар сурталчилж, тайлан мэдээг баримтжуулан, тухайн жилийн 12 дугаар сарын 1-ний дотор “Соёлын өвийг хамгаалах зөвлөл”-д хүргүүлнэ.

2.5.8. Өөрийн амьдардаг нутгийн ойролцоо шинээр дурсгал нээн илрүүлэх, түүх, соёлын үл хөдлөх дурсгалын ойр орчинд зөвшөөрөлгүй металл хайгч, тусгай багаж ашиглаж хууль бус ажиллагаанаас сэргийлж, хянана.

2.5.9. Гэрээт хамгаалагч нь аймгийн Засаг даргаас тогтоосон түүх соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах зардлыг жил тутам сумын Соёлын төвөөр дамжуулан хүлээн авна.

2.5.10. Соёлын тухай хуульд заасан соёлын талаарх иргэний журамт үүргээ биелүүлнэ.

-оOо-